

ӨМӨЗО-НЫ ХОШУУ СЯНИЙ ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛГИЙН ХӨГЖИЛ
ТӨЛӨВШИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Улаан*

*Хөх хотын Үндэстний Дээд Сургуулийн дэд профессор

Түлхүүр үг: ӨМӨЗО-ны телевизийн хөгжил, түүх, хошуу Сяний телевизийн хөтөлбөр

Дундад улсын телевизийн нэвтрүүлэг дөрвөн зэрэглэлийн хэлбэрээр явагддаг. Хошуу Сяний телевиз хороо бол хамгийн эцсийн шатанд орших нэвтрүүлэг болно. ӨМӨЗО-ны телевизийн нэвтрүүлгийн үйлс нь цаг үеийн хөгжлийг дагаж дөч гаруй жилийн хугацаанд нэгэнт сонин мэдээний программ, үйлчилгээний программ, тусгай сэдэвт программ зэрэг байнгын нэвтрүүлэгтэй орон нутгийн өвөрмөц онцлогтой телевизийг бүрэлдүүлвэй.

ӨМӨЗО (хойшид Өвөр Монгол хэмээн товчлон хэрэглэнэ)-ны хошуу Сяний телевиз нь дамжуулах өртөөний сууринд хөгжиж ирсэн бөгөөд эл хошуу Сяний телевиз нэвтрүүлэг эхэлсэн нь бүр сумын мэдээний программаас улиран хөгжиж ирсэн. Сяний телевизийн нэвтрүүлэг өвөр монголчуудад сумын мэдээ мэдээлэх, мэдлэг уламжлах үйлчилгээг хангах, зугаа цэнгэл олгоход чухал нөлөө үзүүлсээр иржээ.

Нэг. Үүслийн шат

1970 онд Хүрээ хошуу хамгийн анх дамжуулах өртөө байгуулснаас 1987 онд өвөр монгол радио телевизэд бичил долгионы шугам нэвтэрсэн

хугацааг үүслийн шат болгон төрөлжүүлэв. 1969 онд Өвөр Монголын телевизийн хороо Хөх хотод байгуулагдаж, 1976 оны 10 дугаар сарын 2-ны өдрөөс монгол хэлний нэвтрүүлгээ эхлүүлсэн байна. Өвөр Монгол нь Дундад улсын хувьд хамгийн эрт телевизийн хороо байгуулсан цөөн тоот үндэстний өөртөө засах орон болно.

Аймаг, хотын хэмжээнд 1971 оны IV сард Зуу Уд аймгийн телевиз хороо хамгийн анх байгуулагдаж улмаар Бугат (1971 он X сард), Жирэм (1973 оны X сард), Хөлөн буйр (1973 оны XI сард), Их зуу (1975 онд) зэрэг аймаг хотын телевиз хороо урьд хожид байгуулагдав¹.

Эл аймаг хотын телевизийн нэвтрүүлгийн хөгжил нь хошуу Сяний телевиз нэвтрүүлгийн эхлэлд асар их нөлөөлжээ. Нөгөө талаас нийгмийн хөгжлийн үүднээс авч үзвэл энэ хугацаанд Сяний цахилгаан хангалт тогтвортой болж, иргэдийн цахилгаан хэрэгслийн хэрэглээ баталгаатай болсон. Үүний зэрэгцээ өнгөрсөн зууны 80-аад он болоход иргэдийн амьдралын түвшин сайжирч, телевиз нь энгийн ардын хэрэглээ болсон. Жишээлбэл, Зуу Уд аймгийн Аохон хошуунд 1976 онд нийт хошуунд зөвхөн ганц телевизтэй байсан бол 1985 онд нийт хошууны өнгөт болон хар телевиз 2400

гаруй болов². Хөлөн Буйр хотоор жишээлбэл өнгөрсөн зууны 80-аад онд хотын хэмжээнд 16 түмэн телевиз байж, хоёр гурван айлын дунд нэг телевизтэй болжээ. Эдгээр бусад нөхцөл нь хожим телевизийн нэвтрүүлэг түгээмэлжих нийгмийн урьдач нөхцлийг хагасан юм³.

Өвөр Монголд хамгийн анх телевиз нэвтрүүлгийг эхлүүсэн хошуу бол Хүрээ хошуу (1970 он), улмаар Баарин зүүн хошуу (1971 он), Чин ши хэ сянь (1972 он), Гу янь шянь (1974 он), Тогтох хошуу (1975 он), Яг ши (1975 он) зэрэг болно.

1983 онд Бээжинд хуралдсан Дундад улсын XI хугацааны Радио телевизийн хуралдаан Дундад улсын телевизийн үйл ажиллагаа, цаашдын хөгжилд тэмдэглэгдсэн чухал үйлс болов. Уг хуралд “дөрвөн зэрэглэлээр телевиз эрхлэх, дөрвөн зэрэглэлээр холилдон бүрхсэн бүс нутагтаа тохирсон, зэрэглэл хуваан бүтээн байгуулах” гэх төрийн бодлогыг дурдаж⁴, энэ бодлогоор Өвөр Монгол эл хошуу Сяний телевиз нь бухиа ба телевиз дамжуулах өртөөг байгуулав. Тус төрийн бодлогыг хэрэгжүүлсээр Төв болон муж орон, шууд хараат хотын хоёр зэрэглэлийн радио телевиз хороо байгуулахаас гадна бусад аймаг хот, хошуу Сянь тухайн газрын бодитой нөхцлийг үндэслэн Телевизийн хороо байгуулж, доор шатны Телевизийн хороо нь Төв болон Өөртөө засах орны телевизийн хөтөлбөрийг дамжуулан нэвтрүүлэхээр гол болгож, тухай газар орон нь өөрийн телевизийн хөтөлбөрөө бас нэвтрүүлж, үүнээс эхлээд хошуу Сяний телевизийн нэвтрүүлэг жинхэнэ утгаар хөгжин төлөвшиж эхэлсэн юм.

Ийнхүү Дундад улсын Төрийн явдлын хорооноос цөөн тоот үндэстний хошуу Сяньд телевизийн нэвтрүүлэг эрхлэх заавар гаргаснаас эл цөөн тоот

үндэстний өөртөө засах орон, аймаг хотын Телевизийн хороо нь тухайн намын хороо, аймгийн захиргааны удирдлагаар тус үндэстний хэлээр нэвтрүүлэг хийж эхлэв. Энэ их хурлаас өмнө хошуу Сяний телевиз нэвтрүүлэг нь бүр Телевиз дамжуулах өртөө хэмээн нэрлэж байсан бол Радио телевиз хороо хэмээн нэрийдэх болов. Телевиз дамжуулах өртөө нь Дундад улсын Төв телевиз хорооны нэгдүгээр сувгийн нэвтрүүлэг ба Өвөр монголын телевиз хорооны нэвтрүүлгийг дамжуулж байв.

Энэ хурал нь ӨМӨЗО-ны хошуу Сяний телевиз дамжуулгын үүслийг ихээр ахиулав. Тухайлбал, 1984 оноос Улаан цав аймгийн Жуэзы Сяньд зэрэг хошуу Сяний телевиз дамжуулах өртөө байгуулан бүх аймаг нийт 90 суурь телевиз дамжуулах өртөөтэй болж, цацалтын ерөнхий чадамж нь 20 километр байж, холимог бүрхэц нь тухайн үеийн Улаан цав аймгийн бүх хүн амын зууны нааяас дээш хүрэв.

Баяннуур хотоор жишээлбэл 1984 онд Баяннуур хотын захиргаанаас телевизийн үйлст хоёр сая юаны хөрөнгө оруулжээ. Энэ хөрөнгө оруулалт нь Баяннуур хотын хошуу Сяньд телевизийн хөгжилд дутагдаж болшгүй хүчин зүтгэл үзүүлсэн. 1985 онд Хөххотоос Баян хот хүрэх радио телевиз нэвтрүүлгийн бичил долгионы шугамын инженерийн ажлыг эхэлж 1986 онд Баян нуур, Хянган хойд хошуу, Урадын өмнөд хошуу, Урадын дундад хошуу, Урадын хойд хошуунд урьд хожид телевизийн нэвтрүүлэг эхэлжээ.

1969 онд Өвөр Монголын Одон телевиз эфирээ цацаж эхэлснээс аваад 1986 оны сүүлч хүртэлт 17 жилийн хугацаанд Өвөр Монголд нийт 25 Телевиз хороотой болж, үүнд орны зэрэглэлийн Телевиз хороо 1, Аймаг

хотын зэрэглэлийн Телевиз хороо 12, хошуу Сяний Телевиз хороо 12, Телевизийн программ цацах өртөө, телевиз дамжуулах өртөө, бухиа өртөө нийт 691 суурь хүрчээ. 1987 онд Өвөр Монголын Радио, телевизийн бичил долгионы шугам нэвтэрч Телевиз хороо тус шугамаар аймаг хот ба хошуу сянтай харилцан программ солилцох болов. Тус шугам нэвтэрсэн нь Өвөр Монголын телевизийн үйлс нь цоо шинэ шатанд дэвшин орсныг харуулж байна.

Хошуу Сяний телевиз нэвтрүүлэг нь телевизийн программа баяжуулахын төлөө бусад муж хотын телевизийн программыг дамжуулан нэвтрүүлж байв. Тухайлбал, Зуу Уд аймаг, Ляонин мужийн программыг дам-жуулж байсан түүхтэй. Их зуу аймаг Шаньси мужийн программыг дам-жуулж байсан, Хөлөн буйр Харбин, Шиньянгийн телевизийн программыг дамжуулан нэвтрүүлж байжээ. Морин даваа нь Дагуур үндэстний өөртөө засах хошуу, Чичихарын Телевиз хорооны телевизийн программыг дам-жуулан нэвтрүүлж ирсэн түүхтэй. Бичил долгионы шугам нэвтэрсний дараа дүрс шингэлтийн тайфаар телевизийн программыг дамжуулах түүхийг эцэслүүлсэн байна. 1970-1986 он хүртэлх цаг хугацаа бол хошуу Сяний телевиз хороо голдуу туршлага хуримтлуулж, боловсон хүчин боловсруулж, хожмын хөгжилтөнд таатай нөхцөл бүрэлдүүлсэн үүслийн шат болно.

Хоёр. Хөгжлийн шат

1988-2000 оны хөгжлийн шатны хошуу Сяний телевизийн нэвтрүүлгийн онцлог нь Дундад улсын Төвийн болон Өвөр Монголын хошуу Сяний телевизийн программыг нэвтрүүлэ-хээр гол болгож, зохих хэмжээний бие даан бүтээсэн телевизийн программыг нэвтрүүлж байв. Энэ хугацаан дахь

хошуу Сяний бие даан бүтээсэн телевизийн программ нь сонин мэдээний программаар голлож, нэвтрүүлэх цаг, хугацаа нь маш тогтворгүй байжээ. Өнгөрсөн зууны 90 оны эцэс болоход сая тогтсон программын булангаар тогтмол хугацаагаар нэвтрүүлэх түүхэн шат үед орсон юм.

Хөгжлийн шатанд хошуу Сяний телевиз хороо нь боловсон хүчин, бодисын хүч, тоног төхөөрөмж хүрэлцэхгүйгээс болж зөвхөн тогтмол бус хугацаагаар телевизийн сонин мэдээ нэвтрүүлж байжээ. Хорчин зүүн гарын дундад хошуу, Жарууд хошуу, Долон-нуур Сянь зэрэг хошуу Сянь бол Өвөр Монголын хошуу Сяниас хамгийн анх бие даан телевизийн программ үйлдэн бүтээсэн болно. Хэдийгээр тухайн үеийн телевизийн программ нь дүрэм зүйн бус боловч тухайн үеийн бодисын нөхцөл ба боловсон хүчин хүрэлцэхгүй байдалд малчин түмэнд тухайн хошуу Сяний мэдээ зангийг дамжуулан тараа-хаар чармайсан нь маш зоригтой ажил болно. Хорчин зүүн гарын дундад хошуу 1981 оноос эхлэн бие даан үйлдсэн “Хорчин зүүн гарын дундад хошууны сонин мэдээ” телевизийн программыг тогтмол бус хугацаагаар нэвтрүүлэх болов. Жарууд хошуу 1980 оноос бие даан үйлдсэн зураг дүрс үгүй “Жарууд хошууны сонин мэдээ” болон “Цаг уурын урьдчилсан мэдээ” нэвтрүүлж, 1985 оны VI сараас тогтмол бус хугацаагаар телевиз, сонин мэдээ “Жарууд хошууны сонин мэдээ”, “Таваарын мэдээ занги”, “Тусгай сэдэвт мэдээлэл”, “Сурган хүмүүжлийн программ”-ыг бие даан үйлдэх болжээ.

Хошуу Сяний хүлээн авагчийн олонхи нь тус нутгийн иргэд тул Өвөр Монголын эл хошуу Сяний телевизийн нэвтрүүлэг нь орон нутгийн онцлог

товойн илрэх нь гарцаагүй. Хошуу Сяний телевиз нь хамгийн үндсэн шатны мэдээллийн хэрэгслэл болж ард түмний амьдралд ойртож, тэдний хамгийн үндсэн хэрэгцээг хангаж чаддаг. Өнгөрсөн зууны 80-аад оны эцсээс хошуу Сяний телевиз нэвтрүүлэг нь сонин мэдээнээс гадна, үйлчилгээний программыг эхэлж бэлтгэн нэвтрүүлсэн. Эдгээр программ нь хошууны ард түмэнд үйлчлэхээр зорилго болгож ажил амьдрал хэрэгцээтэй хамгийн шинэ мэдээ зангийг дамжуулахын хамт хөдөө орон нутагт хэрэгжүүлж байгаа эл зүйлийн эдийн засгийн төрийн бодлогыг тайлбарлаж, түүний шинжлэх ухааны мэргэжлийг түгээмэлжүүлэн дэлгэрүүлэхийг гол зорилго болгож байжээ. Үүнд “Онигууд хошууны мэдээ занги”, “Баарин зүүн хошууны эдийн засгийн мэдээ”, “Хишигтэн хошууны зар мэдээ” зэрэг үйлчилгээний программыг дурдаж болно.

Дундад улсын эдийн засаг тасралтгүй өөрчлөгдөхийн дагуу хошуу Сяний телевизийн үйлс алгуур аажмаар бузгайрч, утасгүй телевизээс утаст телевиз зүг шилжсэн юм. Утаст телевиз бол утасгүй телевизийн хөгжилт, өрөгжилт, нөхөрлөл, тэр нь сувгийн багтаамжаар их, зураг дүрсний чанар сайн, хугацаа урт, дамжуулгын хурдац түргэн, үйлчлэх чадавхи олон зэрэг онцлогтой болохоор утасгүй телевизээс давуу байдаг.

Хошуу Сяний телевизийн нэвтрүүлгийн түүхэн хөгжилтийг ажиглавал нэвтрүүлгийн агуулга нь тухайн газар орны ардын амьрал, хөдөө аж ахуй, ажил олголт, үндэстний орны бүтээн байгуулалттай нягт холбогдсон мэдээ зангийг хамаарч, хэлбэрийн хувьд сонин мэдээ, үйлчилгээний программаар голлож, тогтмол хугацаатайгаар олон ангит кино дамжуулан

нэвтрүүлж тогтмол бус хугацаагаар тусгай сэдэвт ярилцлагын программыг бүтээдэг. Энэ хугацаанд телевизийн нэвтрүүлгийн агуулга дан цулгай, хэлбэр нь дөхөм байжээ.

Гурав. Төлөвшлийн шат

2001-2014 онд Өвөр Монголын хошуу Сяний телевизийн нэвтрүүлэг нь “Тосгон бүхэнд нэвтрүүлэх инженерг”, “Төвд Шиньжаны инженерг” зэрэг том инженерийн ажлыг өрнүүлсээр төлөвшлийн шатанд шилжин оржээ. Өвөр Монголын нутаг дэвсгэр уудам, хүн ам цөөн, тархай бутархай сууршиж байгаа тул үндсэн шатны телевиз программ нь зөвхөн хошуу Сянд хүлээж авч чаддаг. Хөдөө орон нутаг, ой шугамын орны олог түмэн хүлээн авч үзэхэд туйлын хүчир байдаг. Хошуу Сяний телевиз бүрхэвч доор байх асуудал бол хөгжилтийн шатан дахь хошуу Сяний телевизийн нэвтрүүлэгийн шийдвэрлэх чухал асуудал болж байв. 1998 оноос Дундад улсаас “Төвд Шиньжаны инженерг”-ийг өрнүүлж, хил хязгаар орны телевизийн үйлсийг бүтээн байгуулж, энэ хоёр инженерийн ажлыг Өвөр Монголын хошуу Сяний телевизийн бүрхэвчийг ихээхэн нэмэгдүүлжээ. 2008 оны VI сард “Зун шин IX дугаарт дагуулууд”-ыг амжилттай хөөргөсөн нь утас телевизийн бүрхэвч дор хил хязгаар орны олон түмэн телевиз үзэж дийлэхгүй байдлыг өөрчилжээ.

Хошуу Сяний телевиз хорооны тоног төхөөрөмжийн сайжруулалтыг дагалдан бие даан үйлдэх программ нь ч агуулга, төрөл зүйлээр баяжиж, бүтэц нь ч Ерөнхий найруулах хэлтэс, Сонин мэдээний хэлтэс, Монгол хэлний найруулах хэлтэс, Үйлдэн бүтээх хэлтэс, Мэрэгжлийн хэлтэс жич Арван гэрийн тохируулга зэрэг бүрэн төгөлдөр хамааралтын системтэй болов.

Энэ хугацаанд Хошуу Сяний телевизийн программ нь голдуу, сонин мэдээний программ, үйлчилгээний программ, соёл урлагийн программ гэх гурван төрлөөр голлож байжээ. Сонин мэдээний программыг хятад, монгол хоёр хэлээр нэвтрүүлж, удаа бүр 10 минут байж, даваа, лхагва, баасан гаригт монгол хэлээр, мягмар, пүрэв, бямба гаригт хятад хэлээр гэх мэтчилэн өдөр алгасан нэвтрүүлдэг. Агуулын хувьд хошууны нам засгийн чухал шийдвэр бодлого, нийгэм эдийн засгийн хөгжилтийн байдал, хошууны хүрээнд үүссэн шинэ хэрэг учир, цаг төрийн сонин мэдээ, баяжлын мэдээ ухуулга, нийгмийн халамжийн асуудал, иргэдийн амьдралтай холбогдох асуудлуудыг цаг тухайд нь мэдээлдэг.

2001 оноос Соёл урлагийн төрлийн телевизийн программ маш олноор илрэв. Үндэстний онцлог ба орон нутгийн үнэр амтаар гүн зузаан, хошуу Сяний онцлогт тохирсон олон түмэнд ойртсон нөлөө тусгал сайтай телевизийн программ буй болжээ. Энэ бол тус хугацааны товойх онцлог болно. Өүшин хошууны “Номын бүрд”, Отог хошууны “Бүх үзэмжит отог”, Хангин хошууны “Хангин соёл”, Хөвөөт шар хошууны “Нутаг эрдэм”, Шулуун хөх хошууны “Өнөдийн Шандын гол”, Сөнөд зүүн хошууны “Миний сайхан

Сөнөд”, Найман хошууны “Найманы гялбаа”, Хорчин зүүн гарын хошууны “Дархан соёл”, Жарууд хошууны “Жарууд соёл”, Хорчин баруун гарын дундад хошууны “Хорчин соёл” зэрэг телевиз дэлгэц нь үндэстний зан үйл, уламжлалт дадал суртахуун, хүндэлж мэндлэх ёсон, шинэлж цагаалах ёсны үүсэл хувиралт, нутаг усны овоо тахилгын түүхэн эрэлт, домог үлгэрийг тайлбарлан хүмүүст хошуу Сяний хөгжилтийн ул мөр, ирээдүйн хөгжилтийн байдлыг танилцуулахаар дамжуулан хошуу саяниа ухуулан сурталчилж

дотооддоо нутаг орны омогшил сэтгэлгээг дээшлүүлэн, үндэстний нягтралын хүчийг нэмэг дүүлэхийг гол зорилгоо болгожээ.

2009 оны сүүлч болоход Өвөр Монголын аймаг хотын зэрэглэлийн телевиз хороо 14 болж, хошуу Сяний телевиз хороо 76 байж, телевизийн программ 125 болон хөгжиж, телевизийн программ цацах өргөө 1383

суурь, утаст телевизийн хэрэглэгчийн тоо 2,9 сая хүрч, үүнд дижиталчилсан телевиз хэрэглэгч 1,7 сая хүрч, телевизийн бүрхэвч нь 193, 53 утаст телевиз хэрэглэгч 139,38 -д хүрэв⁵.

Өвөр Монголын хошуу Сяний телевиз эхэлсэн 40 гаруй жилийн турш Дундад улсын Төвийн ба Өвөр Монголын Телевиз хорооны нэвтрүүл-



Өвөр Монголын хошуу Сяний телевиз эхэлсэн 40 гаруй жилийн турш Дундад улсын Төвийн ба Өвөр Монголын Телевиз хорооны нэвтрүүлгийг сайтар нэвтрүүлэхээр гол үүргээ болгож, өргөн олон ард түмэнд телевизийн нэвтрүүлгийн цаг тухайд нь нэвтрүүлж байв. Удаан хугацааны хамтын чармайлтаар дамжин Өвөр Монголын хошуу Сяний телевиз нэвтрүүлэг нь бүс нутгийн бүтээн байгуулалтанд зохих хувь нэмэр үзлүүлэн хүлээн авагчдын хүрээллийг олов



гийг сайтар нэвтрүүлэхээр гол үүргээ болгож, өргөн олон ард түмэнд телевизийн нэвтрүүлгийн цаг тухайд нь нэвтрүүлж байв. Удаан хугацааны хамтын чармайлтаар дамжин Өвөр Монголын хошуу Сяний телевиз нэвтрүүлэг нь бүс нутгийн бүтээн байгуулалтанд зохих хувь нэмэр үзлүүлэн хүлээн авагчдын хүрээллийг олов.

Энэ шатанд орон нутгийн эд баялагт түшиглэн хүлээн авагчдын хамгийн ойлгож мэдлэг, хамгийн ойрхон байдаг нь орон нутгийн өвөрмөц онцлогт агуулгад суурилсан маш олон телевизийн нэвтрүүлэгт харагддаг болжээ.

Дөрөв. Уусалчиллын шат

2014 онд Дундад улсын өөрчлөлтийг бүх талаар гүнзгийрүүлэх удирдах дугуйлан ба шинэ хэвлэл мэдээллийг уялдуулан хөгжүүлэхийг жолоодох саналыг хянан зөвлөн баталжээ. Төрийн бодлогын талд уламжлалт хэвлэл мэдээлэл ба шинэ хэвлэл мэдээллийн агуулга, арга зам, тавцан, эзэгнэлт хамааралтын талаар гүнзгий уялдуулахыг шаарджээ. Уламжлалт хэвлэл мэдээлэл шинэ хэвлэл мэдээллийн уусалцан хөгжихийг ахиулж, сонин мэдээ дамжуулгын жам ёс ба шинэ хэвлэл мэдээллийн хөгжилтийн жам ёсыг журамлаж интернет сэтгэлгээг чангатгаж, уламжлалт хэвлэл мэдээлэл ба шинэ хэвлэл мэдээллийн давуу талаа харилцан нөхвөрлөж, мэдээллийн агуулга, эзэгнэлт хамааралт зэрэг талын гүнзгий уусалцан хөгжихийг ахиулж олон хэлбэр, аргачлал ба өрсөлдөх хүчтэй шинэ хэлбэрийн голлох хэвлэл мэдээллийг бүтээн байгуулж, хүчирхэг их бодит хүчин ба дамжуулгын эрчимтэй шинэ хэлбэрийн мэдээллийн хэрэгслийг цогцлоон босоо цогцот олон хэлбэрийн уялдан хөгжсөн шинэ хэлбэрийн мэдээллийн тогтолцоог буй

болгох хэрэгтэй гэдгийг чухалчилсан байна. Энэ нь ӨМӨЗО-ны хошуу Сяний телевизийн өөрчлөлтийг хийхэд маш их нөлөө үзүүлсэн юм.

2014 оноос Өвөр Монголын хошуу Сяний телевиз хороо агуулга, тавцан, эзэгнэлт хамааралтын таван уялдалын тойронд олон төрлийн арга хэмжээ авч голдолготой хүрээ болон чухал хугацааны шатлалтай болжээ. Эдүгээ Өвөр Монголын эл газар нэгэнтэй 38 хошуу Сяний хэвлэл мэдээлэл, уусалчлалын төв байгуулагдаж, уусалчлалын хөгжилт анх алхмын үр бүтээмжийг олж, шинэ цаг үед 5G болон AI зэрэг шинэ мэргэжлийн хэрэглээг эзэмшиж хэвлэл мэдээллийн хөгжилтөнд шинэ аз тохиолыг олгосон байна.

Хөххотын Хорин Гэр Сянь, Тогтох Сянь, Баян нуур хотын Урадын дундад хошуу, Улаанхад хотын ар хорчин хошуу, Шилийн голд аймгийн Авга хошуу, Шулуун хөх хошуу, Улаан цав хотын Дөрвөд хошуу зэрэг уусалцлалын төвийг байгуулжээ. Өвөр Монголын хошуу Сяний уусалчиллын хэвлэл мэдээллийн төв нь тус газар орны хэвлэл мэдээллийн эх сурвалжийг бүтэмжтэй нэгтгэж, олон жилийн турш эл хэвлэл мэдээнийхэн хувь хувиараа бие даан ажилладаг хэвшмэл хэлбэрийг өөрчилж, харилцан уялдаж шинийг үүдэн голлох хэвлэл мэдээллээр удирдлага болгон хэвлэл мэдээллийн хүчин, нөлөөлөх хүчний хөгжилтийг түргэтгэж, хошууны нийгэм эдийн засгийн хөгжилтөд нэн идэвхтэй, нэн сайн үйлчлэхээр чармайсан байна. Хэвлэл мэдээллийн уусалчлалын төв нь хошууны уулын радио телевиз үйлчилгээний төв болон сонины хорооноос бүрэлдэж салаан зэрэглэлийн ажил үйлсийн нэгж болж телевиз, радио, сонин, yuchat, нийтийн тавцан

зэрэг олон төрлийн хэвлэл мэдээллийн төрлийг хамтатгасан уусалчлалын хэвлэл мэдээлэлийн төвийг бүрэлдүүлэхээр чармайж буй.

Өвөр Монголын хошуу Сяний телевизийн үйлс нь 40 жилийн түүхэн хөгжлийн явцад, аль олон гэрэл цацрангуй, түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн яруу хуудсыг бичсэн юм. Эдгээр өв нь Өвөр Монголын хошуу Сяний телевизийн үйлсийн одоо болон ирээдүйн хөгжилд ашиглагдах амьд суурь хөрөнгө болох нь гарцаагүй юм.

Ишлэл

- 1 波烈沁达尔罕,《蒙古语新闻传播史刚要》,呼和浩特市:内蒙古大学出版社,2010年335页
- 2《敖汉旗志》内蒙古人民出版社1991年977页
- 3《呼伦贝尔年鉴》1986年黑龙江人民出版社383页
- 4 李洁琼,《县级电视台生存发展研究》,湖南大学硕士学位论文,2009年32页
- 5《内蒙古统计年鉴》1988年中国统计出版社96页

Ашигласан бүтээлийн жагсаалт

- 1.波烈沁达尔罕,《蒙古语新闻传播史刚要》,呼和浩特市:内蒙古大学出版社,2010年335页

- 2.《敖汉旗志》内蒙古人民出版社1991年977页
- 3.《呼伦贝尔年鉴》1986年黑龙江人民出版社383页
- 4.李洁琼,《县级电视台生存发展研究》,湖南大学硕士学位论文,2009年32页
- 5.《内蒙古统计年鉴》1988年中国统计出版社96页

Агуулгын товч

Дундад улсын ӨМӨЗО-ны хошуу Сяний телевизийн ажил үйлс нь 1970 оноос эхэлж эдүгээ хүртэл 40 гаруй жилийн түүхтэй болжээ. Хошуу Сяний телевизийн үүсэж хөгжсөн ажиллаж эхэлснээс 40 гаруй жилийн түүхийг харвал нялх булбарайгаас боловсронгуй болж хөгжсөн түүхэн явц болно. ӨМӨЗО-ны хошуу Сяний телевиз ажил хэргийн хөгжлийн явцыг үндэслэн цаг хугацааг үечлэн авч үзвэл: Үүслийн, Хөгжлийн, Төлөвшлийн, Уусалчиллын хэмээн дөрвөн үе шат хуваан авч үзэж болно. Тус өгүүлэлд телевизийн нэвтрүүлгийн агуулга, программын төрөл зүйл, эзэгнэлт, хамааралт зэргийг өгүүлж байна. Түүхэн бодисч үзлээр удирдлага болгон өргөн тоочлын аргаар ӨМӨЗО-ны хошуу Сяний телевизийн үйл ажиллагааны түүхэн замналыг өгүүлсэн болно.